

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/283/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН ТӨВИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70272248 Цахим хаяг: byambatsogtj@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Релаэнс секюритиз Аудит" ХХК

Утас: 99813174 Цахим хаяг: rsamongolia@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал.....
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт.....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

ТӨВ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН
ТӨВИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
В.ОТГОНЖАРГАЛ ТАНАА

2024.02.25 № 01/158
танай _____-ны № _____-г

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Жаргалант сумын төвийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Жаргалант сумын төвийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 зорилт 7 арга хэмжээтэй боловсруулан төлөвлөж, 89,7 хувиар хэрэгжүүлсэн байна

Аудитын гол асуудал

Тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

019020287

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	50,656,277.00	130,335,480.46
2	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	4,110,173.06	78,332,786.52
8	Банкинд байгаа бэлэн мөнгө	4,110,173.06	78,332,786.52
9	Төгрөг	4,110,173.06	78,332,786.52
10	Төрийн сангийн харилцах	4,110,173.06	78,332,786.52
27	АВЛАГА	-	1,051,212.00
34	Бусад авлага	-	1,051,212.00
36	Хувь хүмүүсээс авах авлага	-	1,051,212.00
60	БАРАА МАТЕРИАЛ	46,546,103.94	50,951,481.94
66	Хангамжийн материал	46,546,103.94	50,951,481.94
68	Аж ахуйн материал	-	180,000.00
72	Хүнсний материал	-	474,500.00
73	Бусад хангамжийн материал	46,546,103.94	50,296,981.94
86	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	228,441,564.58	219,612,402.54
106	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	228,441,564.58	219,612,402.54
108	Биет хөрөнгө	221,447,564.58	212,618,402.54
109	Барилга, байгууламж	226,253,148.60	226,253,148.60
110	Хуримтлагдсан элэгдэл	(33,675,956.70)	(43,396,595.94)
113	Машин, тоног төхөөрөмж	42,727,040.33	41,737,422.33
114	Хуримтлагдсан элэгдэл	(37,397,348.62)	(37,558,678.88)
115	Тавилга, аж ахуйн эд хогшил	27,382,870.59	27,292,770.59
116	Хуримтлагдсан элэгдэл	(20,229,138.27)	(20,846,826.81)
122	Бусад үндсэн хөрөнгө	26,707,340.00	31,626,740.00
123	Хуримтлагдсан элэгдэл	(13,012,289.35)	(15,181,475.35)
125	Номын фонд	2,691,898.00	2,691,898.00
126	Биет бус хөрөнгө	6,994,000.00	6,994,000.00
127	Програм хангамж	50,000.00	50,000.00
128	Хасагдуулга	(50,000.00)	(50,000.00)
129	Бусад биет бус хөрөнгө	6,994,000.00	6,994,000.00
137	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	279,097,841.58	349,947,883.00
214	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	279,097,841.58	349,947,883.00
215	Засгийн газрын хувь оролцоо	279,097,841.58	349,947,883.00
216	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	70,053,124.95	70,053,124.95
217	Өмч: -Төрийн өмч	70,053,124.95	70,053,124.95
223	Хуримтлагдсан үр дүн	93,876,711.36	164,792,415.19
224	Өмнөх үеийн үр дүн	93,876,711.36	93,942,373.77
225	Тайлант үеийн үр дүн	-	70,850,041.42
227	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	115,168,005.27	115,102,342.86

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,190,555,692.50	479,211,580.00
76	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,013,897,893.91	455,843,380.00
77	Нийтлэг татварын бус орлого	489,139,593.91	2,121,680.00
81	Төсөвт байгууллагын өөрийн орлого	5,745,590.72	-
86	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	5,745,590.72	-
91	Монгол банкны ашиг	387,203,660.31	1,012,000.00
92	Бусад орлого	96,190,342.88	1,109,680.00
99	Тусламжийн орлого	524,758,300.00	453,721,700.00
100	Хандив тусламж /дотоод/	524,758,300.00	453,721,700.00
111	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	176,657,798.59	23,368,200.00
122	Нэмэлт санхүүжилтийн орлого	82,911,200.00	-
126	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	82,911,200.00	-
129	Орон нутгийн төсвөөс санхүүжих	93,746,598.59	23,368,200.00
130	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	93,746,598.59	23,368,200.00
147	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	712,150,227.74	408,361,538.58
148	УРСГАЛ ЗАРДАЛ	712,150,227.74	408,361,538.58
149	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	620,085,327.74	397,626,967.52
150	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	414,014,140.67	262,386,504.68
151	Цалин	315,702,254.59	189,922,634.67
152	Нэмэгдэл цалин	82,688,872.17	66,025,690.93
154	Урамшуулал	15,623,013.91	6,438,179.08
157	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,075,484.71	33,326,942.93
158	Тэтгэврийн даатгалын шимтгэл	33,057,893.72	22,977,631.47
159	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	4,021,715.83	2,745,473.44
160	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	4,078,689.48	2,053,016.99
161	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	786,118.16	504,109.96
162	Эрүүл мэндийн даатгалын хураамж	7,131,067.52	5,046,711.07
164	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,644,358.13	22,306,858.94
165	Гэрэл цахилгааны зардал	7,091,768.15	3,592,386.94
166	Түлш, халаалтын зардал	27,328,589.98	15,703,272.00
167	Цэвэр, бохир усны зардал	4,224,000.00	3,011,200.00
170	Хангамж, бараа материалын зардал	6,388,060.00	5,744,550.00
171	Бичиг хэргийн материал	5,582,860.00	236,000.00
172	Тээвэр, шатахууны зардал	-	3,504,950.00
176	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	465,300.00	1,759,100.00

177	Аж ахуйн материал худалдан авах зардал	339,900.00	244,500.00
181	Нормативт зардал	83,847,790.00	51,222,540.00
182	Эм	-	82,500.00
183	Хоол	83,166,790.00	51,140,040.00
184	Нормын хувцас, зөөлөн эдлэл	681,000.00	-
185	Эд хогшил, урсгал засварын зардал	514,000.00	500,000.00
189	Урсгал засвар	514,000.00	500,000.00
190	Томилолт, зочны зардал	-	814,000.00
192	Дотоод томилолтын зардал	-	814,000.00
194	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	-	3,388,726.93
195	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	2,706,750.00
200	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	-	681,976.93
209	Бараа үйлчилгээний бусад зардал	27,601,494.23	17,936,844.04
210	Бараа үйлчилгээний бусад зардал	6,047,000.00	485,102.00
211	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	-	2,241,280.00
212	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	21,554,494.23	15,210,462.04
224	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	92,064,900.00	10,734,571.06
228	Бусад урсгал шилжүүлэг	92,064,900.00	10,173,230.00
234	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	69,737,000.00	-
235	Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	12,496,600.00	-
236	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	9,831,300.00	10,173,230.00
237	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	561,341.06
240	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	561,341.06
268	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	478,405,464.76	70,850,041.42
276	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	12,985,867.75	-
281	Үнэ төлбөргүй гарсан зардал	12,985,867.75	-
287	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	(12,985,867.75)	-
288	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	465,419,597.01	70,850,041.42

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	701,416,098.59	477,089,900.00
77	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	524,758,300.00	453,721,700.00
100	Тусламжийн орлого	524,758,300.00	453,721,700.00
101	Хандив тусламж /дотоод/	524,758,300.00	453,721,700.00
110	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	176,657,798.59	23,368,200.00
121	Нэмэлт санхүүжилтийн орлого	82,911,200.00	-
125	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	82,911,200.00	-
129	Орон нутгийн төсвөөс санхүүжих	93,746,598.59	23,368,200.00
130	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	93,746,598.59	23,368,200.00
147	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	696,689,964.53	402,867,286.54
148	УРСГАЛ ЗАРДАЛ	696,689,964.53	402,867,286.54
149	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	604,625,064.53	392,132,715.48
150	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	412,280,034.70	263,437,716.68
151	Үндсэн цалин	313,968,148.62	190,973,846.67
152	Нэмэгдэл	82,688,872.17	66,025,690.93
154	Үр дүнгийн урамшуулал	15,623,013.91	6,438,179.08
157	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	50,193,629.68	33,326,942.93
158	Тэтгэврийн даатгалын шимтгэл	34,474,481.09	22,977,631.47
159	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	4,039,715.83	2,745,473.44
160	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	3,003,497.50	2,053,016.99
161	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	786,118.16	504,109.96
162	Эрүүл мэндийн даатгалын хураамж	7,889,817.10	5,046,711.07
164	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	36,583,160.15	22,306,858.94
165	Гэрэл цахилгааны зардал	7,091,768.15	3,592,386.94
166	Түлш, халаалтын зардал	25,267,392.00	15,703,272.00
167	Цэвэр, бохир усны зардал	4,224,000.00	3,011,200.00
170	Хангамж, бараа материалын зардал	414,000.00	-
171	Бичиг хэрэг	414,000.00	-
181	Нормативт зардал	81,910,380.00	51,614,540.00
183	Хоол, хүнс	81,910,380.00	51,614,540.00
185	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	500,000.00
189	Урсгал засвар	1,000,000.00	500,000.00
194	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	61,170.00	674,400.00

200	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	61,170.00	674,400.00
208	Бараа үйлчилгээний бусад зардал	22,182,690.00	20,272,256.93
209	Бараа үйлчилгээний бусад зардал	16,081,480.00	18,030,976.93
210	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	6,101,210.00	2,241,280.00
221	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	92,064,900.00	10,734,571.06
225	Бусад урсгал шилжүүлэг	92,064,900.00	10,173,230.00
231	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	69,737,000.00	-
232	Хөдөө орон нутагт тогвортой ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	12,496,600.00	-
233	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	9,831,300.00	10,173,230.00
234	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	561,341.06
237	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	561,341.06
250	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	4,726,134.06	74,222,613.46
303	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	4,726,134.06	74,222,613.46
304	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	4,110,173.06
305	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,110,173.06	78,332,786.52

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
0	ДАНС	511	51300		
9	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	70,053,124.95	115,168,005.27	93,876,711.36	279,097,841.58
10	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	70,053,124.95	115,168,005.27	93,876,711.36	279,097,841.58
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	132,132.00		65,662.41	65,662.41
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	70,053,124.95	115,168,005.27	93,876,711.36	279,163,503.99
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		(65,662.41)		(65,662.41)
17	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/			70,850,041.42	70,850,041.42
18	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	70,053,124.95	115,168,005.27	164,792,415.19	349,947,883.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1	1	0	100
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	481,297,600.00	402,867,286.54	78,430,313.46	83.7
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	481,297,600.00	402,867,286.54	78,430,313.46	83.7
4	Бараа, үйлчилгээний зардал	471,124,100.00	392,132,715.48	78,991,384.52	83.2
5	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	330,448,100.00	263,437,716.68	67,010,383.32	79.7
6	Үндсэн цалин	226,072,800.00	190,973,846.67	35,098,953.33	84.5
7	Нэмэгдэл	96,415,500.00	66,025,690.93	30,389,809.07	68.5
9	Урамшуулал	7,959,800.00	6,438,179.08	1,521,620.92	80.9
11	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,293,400.00	33,326,942.93	7,966,457.07	80.7
12	Тэтгэврийн даатгал	28,079,400.00	22,977,631.47	5,101,768.53	81.8
13	Тэтгэмжийн даатгал	3,303,500.00	2,745,473.44	558,026.56	83.1
14	ҮОМШӨ ний даатгал	2,642,600.00	2,053,016.99	589,583.01	77.7
15	Ажилгүйдлийн даатгал	660,800.00	504,109.96	156,690.04	76.3
16	Эрүүл мэндийн даатгал	6,607,100.00	5,046,711.07	1,560,388.93	76.4
17	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,868,200.00	22,306,858.94	561,341.06	97.5
18	Гэрэл цахилгаан	4,313,400.00	3,592,386.94	721,013.06	83.3
19	Түлш, халаалт	15,703,300.00	15,703,272.00	28.00	100.0
20	Цэвэр, бохир ус	2,851,500.00	3,011,200.00	(159,700.00)	105.6
30	Нормативт зардал	54,554,800.00	51,614,540.00	2,940,260.00	94.6
32	Хоол, хүнс	54,554,800.00	51,614,540.00	2,940,260.00	94.6
34	Эд хогшил худалдан авах	500,000.00	500,000.00	-	100.0
38	Урсгал засвар	500,000.00	500,000.00	-	100.0
43	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	782,600.00	674,400.00	108,200.00	86.2
49	Мэдээллийн технологийн зардал	782,600.00	674,400.00	108,200.00	86.2
53	Бараа үйлчилгээний бусад зардал	20,677,000.00	20,272,256.93	404,743.07	98.0
54	Бараа үйлчилгээний бусад зардал	18,329,200.00	18,030,976.93	298,223.07	98.4
55	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,347,800.00	2,241,280.00	106,520.00	95.5
66	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,173,500.00	10,734,571.06	(561,071.06)	105.5
70	Бусад урсгал шилжүүлэг	10,173,500.00	10,173,230.00	270.00	100.0
78	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	10,173,500.00	10,173,230.00	270.00	100.0
79	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	561,341.06	(561,341.06)	-
80	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх	-	561,341.06	(561,341.06)	-
97	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	481,198,500.00	477,089,900.00	4,108,600.00	99.1
98	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	454,707,100.00	453,721,700.00	985,400.00	99.8
99	Улсын төсвөөс санхүүжих	454,707,100.00	453,721,700.00	985,400.00	99.8
103	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	23,368,200.00	23,368,200.00	-	100.0
104	Орон нутгийн төсвөөс	23,368,200.00	23,368,200.00	-	100.0
110	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	3,123,200.00	-	3,123,200.00	-
113	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	3,123,200.00	-	3,123,200.00	-
127	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	4,110,173.06	(4,110,173.06)	-
128	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	78,332,786.52	(78,332,786.52)	-
133	АЖИЛЛАГСДЫН ТОО	16.00	16.00	-	100.0
134	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
135	Гүйцэтгэх ажилтан	11.00	11.00	-	100.0
136	Үйлчлэх ажилтан	5.00	5.00	-	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Жаргалант сумын төвийн цэцэрлэг нь сургуулийн өмнөх насны хүүхдийг бие бялдар, оюун ухаан нийгэмшихүй, хөгжлийг хангах чиг үүргийг хэрэгжүүлдэг Боловсрол шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Төв аймгийн Жаргалант сумын төвийн цэцэрлэг нь 2023 оныг "Хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтыг дэмжих" жил болгон зарлаж дэвшүүлсэн зорилго, зорилтын хүрээнд байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 зорилт, 7 арга хэмжээтэйгээр боловсруулан хэрэгжүүлж, төлөвлөгөөг 95,3 хувиар биелүүлж ажилласан байна.

Тус цэцэрлэг нь 16 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Боловсролын тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил гүйлгээ худалдан авах тухай хууль,
- Шилэн дансны тухай хууль,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд мөн Сангийн яам болон харьяа эрүүл мэндийн яамнаас гаргасан тушаал, заавар журам шийдвэрүүдийг мөрдөж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

2023 оны 11 сард аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэг шалгалт хамрагдаж 93,3 хувьтай үнэлэгдсэн.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Жаргалант сумын төвийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Жаргалант сумын төвийн цэцэрлэгийн 2023. оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 70,850.0 мянган төгрөгөөр буюу 25,3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	4,110.1	78,332.7	74,222.6
Авлага		1,051.2	-1,051.2
Урьдчилгаа			
Бараа материал	46,546.1	50,951.4	4,405.3
Үндсэн хөрөнгө	228,441.5	219,612.4	-8,829.1
Нийт хөрөнгө	279,097.7	349,947.7	70,850.0
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	279,097.7	349,947.7	70,850.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	279,097.7	349,947.7	70,850.0

Дээрх хүснэгтээс харахад 2023 оны жилийн эцэст мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 74,222.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь үндсэн, нэмэгдэл цалин, нийгмийн даатгалын шимтгэл зэргээс тус тус хэмнэснээс шалтгаалан өссөн байна.

Авлага дансны үлдэгдэл 1,051.2 мянган төгрөг байна. Энэ нь ажиллагсдаас суутгах авлага байна.

Бараа материал дансны үлдэгдэл 4,405.3 мянган төгрөгөөр өссөн нь хандиваар аймгийн Боловсролын газраас 1,109.7 мянган төгрөгийн 5 ширхэг морин хуур, улсын төсвийн хөрөнгөөр хүнсний бараа материал нөөцөлсөн зэргээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө данс нь 8,829.1 мянган төгрөгөөр буурсан нь сумын ИТХ-н 2023 оны 7 дугаар сарын 06-ны өдрийн 02 тоот тогтоолоор машин тоног төхөөрөмж данснаас 2,001.6 мянган төгрөг, тавилга эд хогшил данснаас 540.0 мянган төгрөг нийт 2,541.6 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус акталсан байна.

Мөн сумын ИТХ-н 2023 оны 7 дугаар сарын 06-ний өдрийн 02 тоот тогтоолоор 410.1 мянган төгрөгийн хангамжийн бараа материалыг данснаас хасаж акталсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 454,707.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 23,368.2 мянган төгрөг нийт зарлагыг 481,198.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг 481,198.5 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 481,198.5 мянган төгрөгөөр тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 454,707.1 мянган төгрөг, 23,368.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 402,867.3 мянган төгрөг буюу 83,7 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 78,430.3 мянган төгрөгөөр, үүнээс үндсэн цалинг 35,098.9 мянган төгрөгөөр, нэмэгдэл цалинг 30,389.8 мянган төгрөгөөр, хоол хүнс 2,940.2 мянган төгрөгөөр, бусад зардал 1,074.2 мянган төгрөгөөр, бүх төрлийн даатгалын зардлаас 7,966.4 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	71801-Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	81605-Эрүүл мэндийг дэмжих	1,173.9	1,082.5	91,4	92,2%
2	81807-Цэцэрлэгийн хүүхдийн хоол	53,317.3	50,380.3	2,937.0	94,5%
3	81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	2,954.2	2,953.5	0.7	99,9%
4	81823-Багш ажилтны мэргэжил дээшлүүлэх	1,199.9	1,199.9		100%
5	81832 Нүүдлийн бүлэгт хамруулах	8,887.5	5,307.8	3,579.7	59,7%
6	81834 Боловсролын стандарт	297,851.3	228,818.8	69,032.5	76,8%
7	81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	92,545.3	89,756.4	2,788.9	97%
8	80111 Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	22,868.2	22,306.5	561.3	97,6%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Жаргалант сумын төвийн цэцэрлэг нь нэмэлт санхүүжилтийн төсөв байхгүй.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	/мянган төгрөгөөр/	
					Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	71801-81605	2023-12-31	Эрүүл мэндийг дэмжих	92,2%	1,173.9	1,082.5
2	71801-81807	2023-12-31	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	94,5%	53,307.3	50,380.3
3	71801-81816	2023-12-31	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	100%	2,954.2	2,954.2
4	71801-81823	2023-12-31	Багш ажилтны мэргэжил дээшлүүлэх	100%	1,199.9	1,199.9
5	71801-81832	2023-12-31	Нүүдлийн бүлэгт хамруулах	59,7%	8,887.5	5,307.8
6	71801-81834	2023-12-31	Боловсролын стандарт	74,8%	297,851.3	228,818.8
7	71801-81835	2023-12-31	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	97%	92,545.3	89,756.4
8	71801-80111	2023-12-31	Тогтмол зардал	97%	92,545.3	89,756.4

Цэцэрлэгийн хүүхдийн хоол арга хэмжээ нь дутуу хэрэгжсэн нь сургуулийн хүүхдийн улирлын амралттай холбоотойгоор хэмнэгдсэн. Нүүдлийн бүлэгт хамруулах арга хэмжээ хангалтгүй хэрэгжсэн нь орон тоо дутуу, хүүхдийн ирц бага байсантай холбоотойгоор хэмнэгдсэн. Эрүүл мэндийг дэмжих арга хэмжээ дутуу хэрэгжсэн нь зарим ажилчид өмнөх онд эрүүл мэндийн үзлэгт хамрагдсантай холбоотой.

Сургалтын хэвийн үйл ажиллагаа арга хэмжээ нь дутуу хэрэгжсэн нь томуу томуу төст өвчин ихэссэн, цахимд шилжсэнтэй холбоотойгоор хүүхдийн ирц буурснаас шалтгаалан хэмнэгдсэн.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тендер зарласан боловч 1 ч аж ахуй нэгж байгууллага оролцоогүй тул Сумын албан бичгээр Арвинбат ХХК-аас 51,614.5 мянган төгрөгийн хүнсний материал, аж ахуйн материал 1,867.6 мянган төгрөг, эм боол материал 82.5 мянган төгрөг, бичиг хэргийн материал 2,442.3 мянган төгрөг, түлш 3,504.9 мянган төгрөг, хангамжийн материал 3,051.3 мянган төгрөг, барилгын засварын материал 816.0 мянган төгрөг нийт 63,379.2 мянган төгрөгийн шууд худалдан авалт хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Жаргалант сумын төвийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах ажиллагчидтай холбоотой авлагыг барагдуулах, дансны үлдэгдлийг улирал, жилийн санхүүгийн эцэст баталгаажуулж байхтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Релаэнс секюритиз аудит” ХХК-ийн аудитор С.Дашдондог, аудитор Б.Мягмар, нар гүйцэтгэж, хяналтыг “Релаэнс секюритиз аудит” ХХК-ийн захирал, аудитор Ж.Цэцэгмаа, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт, аудитын менежер О.Амаржаргал, дарга Тэргүүлэх аудитор Ц. Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Жаргалант сумын төвийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 700,000.0 мянган төгрөгөөс 2,0 хувиар буюу 14,000.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 11,200.0 мянган төгрөгөөр тооцлоо. Аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Жаргалант сумын төвийн цэцэрлэг нь тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон зардлууд гараагүй, өглөг үүсгээгүй төсвийн хөрөнгийг хэмнэлттэй зарцуулан ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Жаргалант сумын төвийн цэцэрлэг нь 2023 онд шилэн дансанд 159 мэдээлэл оруулахаас 153 мэдээллийг хугацаанд нь мэдээлж 6 мэдээлэл хоцроож байршуулсан байна. Энэ нь шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.1-д “Мэдээлэл үнэн зөв бодитой иж бүрэн байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх”, 6.4.4-д “Таван саяаас дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил гүйлгээ”, МУЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 7 дугаар зүйлийн 7.5.3-д “өөрийн хянах цэсийн мэдээллийг байнга хянах” заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид шилэн дансны хуулийг хэрэгжүүлэхдээ нэг ч мэдээлэл хоцруулахгүй байхыг анхааруулж, зөвлөмж өгөв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүнба өмнөх аудитаар өгсөн алдаа зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Жаргалант сумын төвийн цэцэрлэгийн 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар нийт 1,700,0 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд зөрчлийг арилгах 1 зөвлөмж өгч ажиллалаа. Завсрын аудитын зөвлөмжийн биелэлтийг жилийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад зөвлөмж хэрэгжээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон албан шаардлага, зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	1	51,681.1	1	51,681.1	100
Зөвлөмж	2	1,770.1	2	1,770.1	100
Нийт дүн	3	53,451.2	3	53,451.2	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй болно

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,282.3 мянган төгрөгийн 2 зөрчил илэрснээс 1,231.1 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 1,051.2 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

5.2 Албан шаардлага

1. Зардлын данстай холбоотой

Илрүүлэлт:

Хүүхдийн хоолны батлагдсан жишиг нормыг дагаж мөрдөөгүй хоол зарцуулалтын болон хүнсний материалын тайлан хийгээгүй улмаас 1,213.1 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Энэ нь Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А\166, А\556, 222 тоот хамтарсан тушаалын заалт, санхүүгийн тайлангийн “Тохиолдсон байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын /4.2.3.6-д “эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан” гэж заасныг үндэслэн албан шаардлага тогтоов.

5.3 Зөвлөмж

1. Авлага, өглөгийн данстай холбоотой

Илрүүлэлт:

2023 оны санхүүгийн жилийн тайлангаар 1,051.2 мянган төгрөгийн ажилчдаас суутгах авлагын зөрчил илэрсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах” гэсэн хуулийн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Холбогдох хууль тогтоомжийн дагуу авлага өглөгийг хугацаанд нь барагдуулах.

Дээрх албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо		
Батлагдсан жишиг нормыг дагаж мөрдөөгүй хоол зарцуулалтын болон хүнсний материалын тайлан хийгээгүй	1	1,231.1			1	1,231.1						
Ажилчдаас суутгах авлагыг барагдуулаагүй	1	1,051.2					1	1,051.2				
Дүн	1	2,282.3			1	1,231.1	1	1,051.2				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
шилэн дансанд 159 мэдээлэл оруулахаас 6 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан байна	1						1	
Дүн	1						1	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn